

“Бөхөг” ХК-ий 2019 оны үйл ажиллагааны тайлан

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн мэндийг хүргэж, эрүүл энх сайн сайхныг хүсье.

2018-2019 оны үйл ажиллагааны тайланг та бүхэндээ танилцуулъя. 2019 онд нилээд ажил хийхээр төлөвлөсөн боловч хөрөнгө санхүүтэй холбоотой хийгдээгүйд хүлцэл өчье. Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн байдал, тус компаний үйл ажиллагаа удаан хугацаанд зогссонтой холбоотой хөрөнгө оруулалтын ажил хийгдэж чадахгүй байгаа нь жил бүр төлөвлөсөн ажлууд хийгдэж чадахгүй байгаа нь харамсалтай байна. Миний бие гүйцэтгэх захирлын албан тушаалыг авч өөрийн бүхий л бололцоогоо дайчлан ажилласан боловч бүх зүйл санхүүжилттай холбоотой учир төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэж чадсангүй. Гэвч компаний нөөц бололцоонд тулгуурлан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

I. Байгууллагын удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

1.1 Шувууны аж ахуй компаний олон улсын жишгийг судлан, мөн Монголд шувууны аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын үйл ажиллагааг судлан өөрийн компаний бүтэц зохион байгуулалт болон жишиг хэлбэрийг тоймлон гаргаж, ТУЗ-д танилцуулан ажиллаа.

Ер нь цаашид монгол орны нөхцөл байдлын хувьд махны чиглэлийн шувууны аж ахуй болгох нь зүйтэй гэсэн саналыг ТУЗ-д хүргүүлсэн.

Мөн компаний нийт талбайн зурагт дахин кадастрын зургийг хийлгүүлж, дутуу орсон талбайг нэмж хийлгэсэн.

1.2 Удирдлагын чадавхийг сайжруулах чиглэлээр:

Компаний удирдлага, чадавхийг сайжруулах, хүний нөөцийн удирдлагыг чадавхижуулах зэрэг сургалтанд хамрагдсан болно.

1.3 Удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний нөөц бүрдүүлэх боломжийг судлан ажиллаа. Одоогоор санхүүжилт, цалин хөлс байхгүй учраас ТУЗ бас хүчтэй ажиллаж чадахгүй байна.

1.4, 1.5 асуудлууд шийдэгдээгүй.

1.6 Холбогдох дээд байгууллагаас ирсэн бичигтэй танилцан ажиллаа. Хувьцаа эзэмшигч Эрдэнэцогтын ирүүлсэн хүсэлтэд хариу хүргүүлэн ажилласан.

II, III ажлын хүрээнд хийгдсэн ажилгүй байна.

IV. Аж ахуйн чиглэлээр

4.1 Хөрөнгийг бүртгэх ажиллагаа явуулсан боловч зарим тоног төхөөрөмжүүд хуучирч нэр хаяг тодорхойгүй, эвдрэл ихтэй, цаашид ашиглах боломжгүй болсон байна. Тооллогыг бүрэн явуулж чадаагүй.

4.2 Цэвэр, бохир усны байгууламжийн асуудлаар ХУД-ийн орлогч дарга н.Батсайхантай уулзалдаж, хэрхэн шийдвэрлэх талаар хариу хүссэн боловч одоо хүртэл тодорхой хариу өгөөгүй. ХУД-ийн Засаг дарга болон ХУД-ийн 13-р хорооны даргад албан бичгийг хүргүүлэн ажилласан. Нийгмийн хариуцлагын хүрээнд түр ашиглуулах боломж олгохыг хүссэн хүсэлт ирснийг ТУЗ-д танилцуулсан. Цаашид өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх талаар архивын газраас материалыг үзэж шалгаж байна.

4.3 Гал командын байрыг чөлөөлүүлж авсан. Байрны бүрэн бүтэн байдлыг хангасны дараа хүлээн авах болсон.

4.4 – 4.10 хүртэл ажлууд хийгдээгүй.

4.11 Компаний ойр орчимд хогийн цэг байрлуулсныг ХУД-ийн 13-р хорооны Засаг даргад танилцуулан, нүүлгэн шилжүүлэх ажил хийгдсэн. Хашаан доторхи хогийг бүрэн цэвэрлэж, зэрлэг ургамлыг түүлгэсэн. Төмрийн хогийг нэгтгэн байрлуулсан.

V. Санхүүгийн чиглэлээр

5.1 Нэмэлт хувьцаа гаргах талаар “Ард секурити” брокерийн компанитай уулзалт зохион байгуулсан. “Түмэн шувуут” ХХК нь нэмэлт хувьцаа гаргасан учир одоо боломж тун бага болсон. Үүнийг ТУЗ-д танилцуулсан.

5.2 Хөрөнгө оруулалтын чиглэлээр БНХАУ-ын шувууны аж ахуйн компанитай хэд хэдэн удаа уулзалт зохион байгуулсан ба ТУЗ-ийн гишүүн Ц.Чанцал, П.Амарбаяр нарын хамт компанитай танилцан санал солилцсон. Одоо судлагдаж байгаа.

5.3 Санхүү бүртгэлийн үйл ажиллагааг зохих хууль, дүрэм, журмын дагуу баримт бичгийг боловсруулан ХУД-ын санхүүгийн хэлтэс, ХУД-ын татварын хэлтэст тус тус тайлагнаж ажилласан.

Цаашид компаний үйл ажиллагааг явуулах эхний үүсгэвэр мөнгөтэй болгох ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Тайлан бичсэн:

“Бөхөг” ХК-ийн гүйцэтгэх захирал

Д.Отгонбилэг